

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Мандал Даатгал ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, тус тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2022 оны 04 сарын 23-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Мандал Даатгал ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1 ёсоор баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн ТУЗ-ийн гишүүдийг


сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.8 болон Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын 2-р зүйлийн 2.10 дахь хэсэг, Мандал Даатгал ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.8.1 дэх хэсэг, 8-р зүйлийн 8.4 дэх хэсэг, 2022 оны 04 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Мандал Даатгал ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Отгон овогтой Мөнхжаргал болон Батсайхан овогтой Жавхлан нарын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө буюу 2022 оны 04 сарын 23-ны өдрөөр дуусгавар болгосугай.
2. Мандал Даатгал ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Гансүх овогтой Дашдэндэв болон Түмэннасан овогтой Батзул нарыг хувьцаа эзэмшигчдээс олонхын санал авсан тул 2022 оны 04 сарын 23-ны өдрөөс эхлэн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр одоо ажиллаж байгаа ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусах хүртэл буюу 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаатайгаар сонгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг нэн даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Т.Батзул) болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Б.Энхтүвшин) нарт даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны  
зардлын төсөв батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.13 дэх хэсэг, Мандал Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2021 оны 04 сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын №21/003 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Мандал Даатгал ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.8.1 болон 7.8.7 дэх хэсэг, 2022 оны 04 сарын 23-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр баталсугай:

Д/д	Зардлын төсөв	Нийт зардал /төгрөг/
1	ТУЗ-ийн дарга болон бусад найман гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, цалин, урамшуулал	154,000,000
2	Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурал	20,000,000
3	Бичиг хэрэг болон бусад	6,000,000
	<b>Дүн</b>	<b>180,000,000</b>

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ